



Европын Холбоо
санхүүжүүлэв



European Bank
for Reconstruction and Development



ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМААР ЯВУУЛАХ ЖУРАМ

Төсөл

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-аас Европын Холбооны санхүүжилтээр Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” (2023-2025) төслийн хүрээнд боловсруулав.

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМААР ЯВУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Цахим эвлэрүүлэн зуучлал нь талууд болон эвлэрүүлэн зуучлагчийг алсаас уулзалт хийх боломжийг олгохын тулд цахим видео хурлын платформыг ашиглан маргаан шийдвэрлэх үйл явц юм.

1.2. Цахим эвлэрүүлэн зуучлалын хувьд холимог хэлбэрээр явуулахаас бусад тохиолдолд аливаа үйл явцыг цахим платформ (Zoom, Skype, Teams зэрэг видео хурлын үйлчилгээ үзүүлэгч) ашиглан алсаас явуулна.

1.3. Эвлэрүүлэн зуучлагч нь асуудлыг шийдвэрлэхэд таатай орчныг бүрдүүлэхийн тулд ажиллагааг эхнээс нь сайн төлөвлөж, холбогдох бүх тоног төхөөрөмж, функцийн талаар мэдлэгтэй байна.

ХОЁР. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМААР БУЮУ ХОЛИМОГ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ НЬ

2.1. Цахимаар эвлэрүүлэн зуучлалыг бие даасан байдлаар эсвэл уламжлалт аргатай хослуулан холимог (hybrid) арга хэлбэрээр ашиглаж болно.

2.2. Талууд зөвшилцсөн тохиолдолд цахим эвлэрүүлэн зуучлалыг бие даасан арга хэлбэрээр эсхүл холимог хэлбэрээр ашиглаж болно. Цахим буюу холимог аргыг дараах үндэслэлээр сонгож болно:

2.2.1. талууд хоорондоо маргаан зөрчилдөөн ихтэй;

2.2.2. цаг хугацаа, зардлыг хэмнэх зэрэг шалтгаанаар талууд биечлэн уулзах хүсэлгүй;

2.2.3. талууд болон тэдгээрийн өмгөөлөгчид хуралд биечлэн оролцох боломжгүй;

2.2.4. биечлэн ирж, очиход хүндрэлтэй.

2.3. Холимог аргыг хэрэглэх үед цахим болон биечлэн уулзах аргыг хослуулан хэрэглэж болно. Ингэснээр оролцогчдын зарим нь нүүр тулан уулзаж, зарим нь

утсаар эсвэл цахимаар оролцох боломжтой. Түүнчлэн тухайн үеийн нөхцөл байдал, талуудын хүсэлтийн дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлээд цахим хэлбэрээр явуулах ба дараагийн шатанд биечлэн эвлэрүүлэн зуучлах аргад шилжиж болно.

2.4. Аль нэг талын эсэргүүцэл эсвэл маргаан гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд эвлэрүүлэн зуучлагч нь зуучлалын ажиллагаа хэрхэн явагдах талаар талууд урьдчилан тохиролцох ёстойг сануулах үүрэгтэй.

ГУРАВ. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМААР ЯВУУЛАХ ТУСГАЙ ЖУРАМ

3.1. Хувийн нууц ба нууц хадгалах үүрэг

3.1.1.Эвлэрүүлэн зуучлагч болон оролцогчид бодит байдлын хувьд нэг өрөөнд биш, зөвхөн цахим хэлбэрээр, сонгосон платформ дээр уулзаж байгаа нь хувийн нууц, нууц хадгалах үүргийн хэрэгжилтийг хангахад хүндрэл үүсэх эрсдэлтэй.

3.1.2.Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох эрх бүхий этгээдээс бусад этгээдийг оролцуулахгүй байх эсхүл эвлэрүүлэн зуучлалын оролцогчдыг бусад этгээд харах, сонсохыг зөвшөөрөхгүй байх талаар бичгээр тохиролцож, хуралдаан бүрийн эхэнд сануулна.

3.2. Бичлэг хийхийг хориглох

3.2.1. Хувийн нууц, нууцыг хадгалах үүднээс эвлэрүүлэн зуучлагч, талууд, тэдгээрийн өмгөөлөгч зэрэг хэн ч эвлэрүүлэн зуучлалын хуралдааныг бүхэлд нь буюу хэсэгчлэн бичиж болохгүй. Үйл явцын нууцлалыг хангах үүднээс зөвшөөрөлгүй бичлэг хийсэн тохиолдолд уг хурлын аудио, дүрс бичлэгийг устгаж, гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй. Үүнийг эвлэрүүлэн зуучлагч талуудад тайлбарлаж, боломжтой бол эвлэрүүлэн зуучлах дотоод журамдаа тусгах ёстой.

3.3. Хууль тогтоомж

3.3.1. Эвлэрүүлэн зуучлалын явцад нууцыг хадгалахад холбогдох улсын хуулийг баримтална. Тиймээс эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрэглэх хуулийн талаар талууд болон эвлэрүүлэн зуучлагч аль хэдийн тохиролцсон бол уг асуудлыг тухайн холбогдох улсын хуулиар /Монгол Улсын хуулийг сонгосон бол Монгол улсын холбогдох хуулийг мөрдөнө/ зохицуулна.

3.3.2. Эвлэрүүлэн зуучлах төвийн Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам батлагдаагүй бол эвлэрүүлэн зуучлагч, талууд эдгээр асуудлыг (ялангуяа хувийн болон нууцлалыг хамгаалах үүрэг) эвлэрүүлэн зуучлах гэрээнд тусгаж, эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн анхны уулзалтаар талууд гарын үсэг зурж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад бүх оролцогчдод дагаж мөрдөнө: Үүнд:

3.3.2.1.Эвлэрүүлэн зуучлах хуралдаан нь талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчээс бусад этгээд болон талуудын зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлагчийн урьсан этгээдээс бусад бүх этгээдэд хаалттай байна.

3.3.2.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч бус хүмүүсийг оролцуулахгүй байх нөхцлийг хангасан газар ажиллагааг явуулна.

3.3.2.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад оролцогч нь бусад оролцогчийн дэлгэсэн бүх мэдээлэл, баримт бичгийн нууцыг хадгална.

3.3.2.4.Уулзалтын бичлэгийг ямар ч үед хийхийг хориглоно.

ДӨРӨВ.ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

4.1. Төхөөрөмж: Оролцогч нь ухаалаг утас, таблет, зөөврийн компьютер ашиглан цахим хуралд оролцох боломжтой ямар ч төхөөрөмжийг ашиглан зуучлах ажиллагаанд цахимаар оролцож болно. Гэвч бусадтай үр дүнтэй харилцахын тулд оролцогчид микрофон, спикер, камертай ширээний компьютер буюу зөөврийн компьютер ашиглах нь зүйтэй. Чихэвч ашиглаж болох бөгөөд энэ нь нууцлалын нэмэлт баталгааг өгөх болно.

4.2. Интернетийн холболт, програм хангамж: Зуучлагч, оролцлогчдын ажиллагааны явцыг илүү үр дүнтэй болгох, цахим хэрэгслийг ашиглах, баримт бичгийг илгээх, хүлээн авахын тулд тогтвортой, аюулгүй, өндөр хурдны интернет холболттой байх шаардлагатай. Оролцогчид ашиглах цахим хурлын платформын хамгийн сүүлийн хувилбарыг шинэчлэн татаж авах нь зүйтэй.

4.3.Цахим баримт бичиг дамжуулах: Хуралдааны үеэр талууд болон эвлэрүүлэн зуучлагчийн хооронд бичиг баримт солилцох шаардлагатай болдог. Тохиромжтой платформыг сонгосноор дэлгэцэн дээр баримтаа гаргаж танилцуулах боломжтой байсан ч хурлын тэмдэглэл, эвлэрлийн гэрээ зэрэг баримт бичгийг илгээх, хүлээн авах хэрэгцээ зайлшгүй гарна. Иймд баримт бичгийг харилцан илгээхийн тулд эвлэрүүлэн зуучлагч болон талууд дараахь шийдлүүдийн нэг буюу хэд хэдэн хувилбарыг ашиглахаар урьдчилан тохиролцсон байх ёстой. Үүнд:

4.3.1.Цахим хурлын платформын дэлгэцийн функц дээр баримт бичгийг хуваалцах;

4.3.2.Цахим шуудангаар илгээх;

4.3.3.Цахим баримт хуваалцах платформ ашиглах (Dropbox, Google Drive, OneDrive гэх мэт) эсхүл

4.3.4. Цахим хурлын платформд суулгасан цахим баримт хуваалцах хэрэгсэл.

4.4.Цахим хурлын платформ: Цахим эвлэрүүлэн зуучлалыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд аюулгүй бөгөөд зохистой цахим хурлын платформ ашиглах нь чухал. Zoom, Webex, GoToMeeting, Teams, Skype зэрэг хэд хэдэн ийм төрлийн платформ байдаг. Эвлэрүүлэн зуучлагчийн хувьд платформын мэргэжлийн буюу бизнест зориулсан хувилбарыг ашиглах шаардлагатай.

4.5.Эвлэрүүлэн зуучлагч нь талуудтай тохиролцон дараах шаардлагыг хангасан платформыг сонгоно. Үүнд:

4.5.1. Эвлэрүүлэн зуучлагч нь цахим хурлын зохион байгуулагчийн хувьд оролцогчдыг хэзээ оруулах, дууг нь хаах, бичиг баримтыг хуваалцах, завсарлагааны өрөө үүсгэх, нээх, хаах зэргийг шийдэх эрхтэй байх;

4.5.2. Эвлэрүүлэн зуучлагч тэднийг нэгдсэн хуралдаанд оруулах хүртэл хүлээлгийн танхимд байлгах;

4.5.3. Оролцогчид болон эвлэрүүлэн зуучлагч бүгд харилцан ярилцаж, хэлэлцээ хийх хамтарсан хурлын танхимтай байх;

4.5.4. Эвлэрүүлэн зуучлагчийг бүлгийн хуралдаанд зориулан хэд хэдэн тусдаа хуралдаанд хуваах боломжийг олгож болох ба оролцогч бүр эвлэрүүлэн зуучлах ажиллагааны холбогдох асуудлыг бусад талуудгүйгээр, нууцлалыг ханган хэлэлцэх боломжтой байх танхимуудтай байх;

4.5.5. Бүх оролцогчид эсвэл зарим оролцогчид мессеж илгээх чатын системтэй байх. (Энд дурдагдаж буй нэгдсэн хурлын танхим, хүлээлгийн танхим гэдэг нь өрөө тасалгаа биш цахим хурлын програм дахь групп болохыг анхаарна уу.)

4.6.Гарын үсэг: Эвлэрүүлэн зуучлалын хуралдааны төгсгөлд тэмдэглэлд гарын үсэг зурж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурна. Эвлэрүүлэн зуучлагч эдгээр баримт бичгүүдийг

тохиролцож, эцэслэн баталгаажуулсны дараа талуудтай гарын үсэг зурах дараах сонголтоос сонгох талаар урьдчилан тохиролцсон байна. Үүнд:

4.6.1.Эвлэрийн гэрээнд цахим буюу тоон гарын үсэг зурах;

4.6.2.Эвлэрийн гэрээг талууд хоорондоо цахим шуудангаар (pdf хувилбараар) солилцох, эсхүл талуудын гараар бичсэн гарын үсэгтэй хувийг илгээж, дараа нь гарын үсэг зурсан эх хувийг цаасан хэлбэрээр илгээнэ.

ТАВ. ЦАХИМ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

5.1.Дараах нөхцлийн аль нэг нь хангагдсан үед цахим эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулна. Үүнд:

5.1.1.Эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлэх тухай заалт: Талууд гэрээнд тусгайлсан заалт оруулах замаар гэрээнээс үүдэн гарах бүх маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлж болно. Цаашид маргаан гарах тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цахимаар явуулах боломжтой гэж талууд үзэж урьдчилан тохиролцсон бол эвлэрүүлэн зуучлалын тухай заалтад цахимаар явуулах тухай зааж өгч болно. Маргаан шийдвэрлэх тухай заалтад зөвхөн эвлэрүүлэн зуучлалын талаар дурдсан байсан ч нэмэлт тайлбаргүйгээр маргаан гарсны дараа цахимаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах журмын талаар тохиролцож болно.

5.1.2.Эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлүүлэх хүсэлт: Гэрээний талуудын хооронд маргаан үүссэн бөгөөд гэрээнд эвлэрүүлэн зуучлалын тухай заалт тусгагдаагүй үед нөгөө талтай эвлэрүүлэн зуучлалаар асуудлаа шийдвэрлүүлэх хүсэлт хүргүүлэхэд хүндрэлтэй байдаг. Энэ тохиолдолд аль нэг тал эвлэрүүлэн зуучлах журмаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтийг Эвлэрүүлэн зуучлах төвд гаргаж болно.

5.1.3.Шүүхээс эвлэрүүлэн зуучлалд шилжүүлсэн: Шүүх талуудыг эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлэх боломжтой талаар тайлбарлах үүрэгтэй байдаг. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн (Төсөл 2024) 6 дугаар зүйлийн 6.3-т Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно гэж заасан.¹

ЗУРГАА.ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ НЬ

¹ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөл 2024

6.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цахимаар явуулах хүсэлт: Цахим эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэхийн тулд өргөдөл гаргач тал нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цахим хэлбэрээр явуулах тухай хүсэлт гаргана. Хүсэлтийг гараар, шуудангаар, цахим шуудангаар эсвэл боломжтой бол тухайн цахимаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах өргөдлийн загварыг бөглөх байдлаар цахимаар шууд илгээж болно.

6.2. Эвлэрүүлэн зуучлах тухай заалт гэрээнд байгаа бол уг зүйлийн холбогдох заалтын дагуу эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтийн төслийг боловсруулж болно.

6.3. Эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтийн агуулга, хэлбэр нь дараах нөхцөл байдлаас хамаарна.

6.3.1. Талуудын хооронд маргаанаа эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх журмын тухай өмнө нь тохиролцсон эсэх;

6.3.2. Холбогдох хууль: Эвлэрүүлэн зуучлах хүсэлтийн талаар холбогдох хуульд тодорхой заалт оруулж болно;

6.3.3. Сонгосон эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэгчийн баталсан эвлэрүүлэн зуучлалын журмын заалт;

6.4. Онлайн эвлэрүүлэн зуучлах хүсэлт гаргах хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна.

6.4.1. Маргааны талуудын нэр, холбоо барих мэдээлэл, шаардлагатай бол тэдний өмгөөлөгчийн тухай мэдээлэл;

6.4.2. Маргааны агуулгын тухай товч мэдээлэл;

6.4.3. Маргаж буй үнийн дүн;

6.4.4. Ажиллагааны явуулах арга хэлбэр (цахим, биечлэн эсвэл холимог);

6.4.5. Шаардлагатай бусад баримт бичиг.

6.5. Уригдаж буй тал уг хүсэлтийг хүлээн авах эсэхээ шийдвэрлэнэ.

6.6. Зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах гэрээнд гарын үсэг зурж, эвлэрүүлэх ажиллагааг эхлүүлж болно.

ДОЛОО.ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БЭЛТГЭЛ

7.1. Өргөдөл гаргагчийн хүсэлтэд уригдагч тал зөвшөөрсний дараа талууд эвлэрүүлэн зуучлагчийг өөрсдөө сонгоогүй тохиолдолд Эвлэрүүлэн зуучлах төв зуучлагчийг томилно.

7.2. Томилогдсон эвлэрүүлэн зуучлагч нь тухайн хэргийг хүлээн авах эсэхээ шийдвэрлэхдээ дараах нөхцлийг харгалзан үзнэ. Үүнд:

7.2.1. Шударга байдал;

7.2.2. Төвийг сахисан байдал;

7.2.3. Хараат бус байдал;

7.2.4. Тухайн эвлэрүүлэн зуучлалыг удирдах мэргэжлийн туршлага, чадавхи.

7.3.Эвлэрүүлэн зуучлах төв нь уригдсан тал руу зуучлах хүсэлт илгээх, тухайн талын хүлээн зөвшөөрлийг хүлээн авах, эвлэрүүлэн зуучлагчийг томилох, анхны уулзалтыг хийх зэргийг ажлыг гүйцэтгэнэ.

7.4.Эвлэрүүлэн зуучлалын тогтсон практикаар элэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлах хуралдааны өмнө болон бусад шаардлагатай үед дараах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

7.4.1.Холбоо барих: Эвлэрүүлэн зуучлагч тохиромжтой гэж үзвэл утсаар, цахим шуудан эсвэл цахим хурлын платформ ашиглан талууд болон тэдний өмгөөлөгчөөр өөрийгөө танилцуулж, үр бүтээлтэй, найдвартай харилцаа тогтоох;

7.4.2.Эвлэрүүлэн зуучлалын зорилго, түүнийг хэрхэн явуулах талаар талуудад тайлбарлах;

7.4.3.Талууд болон тэдний өмгөөлөгчтэй тохиролцон эвлэрүүлэн зуучлах хуралдааныг зохион байгуулах;

7.4.4.Талууд болон тэдний өмгөөлөгчийн хамт хурлын үргэлжлэх хугацаа, завсарлагааны талаар төлөвлөх;

7.4.5.Цахим хурлын платформыг сонгох;

7.4.6.Цахим хурлын платформтой танилцах;

7.4.7.Талуудын технологи болон сонгосон платформд итгэх итгэлийг судлах;

7.4.8. Сонгосон платформ дээр туршилт хийх эсэхийг талууд болон тэдний өмгөөлөгчдөөс асуух;

7.4.9. Технологийн эвдрэлийн протоколыг заах;

7.4.10. Төлөвлөсөн өдөр, цагт цахим платформтой холбогдох холбоосыг талуудад илгээх;

7.4.11. Эвлэрүүлэн зуучлах цахим хурал болохоос 2-оос доошгүй хоногийн өмнө талууд болон тэдний өмгөөлөгчөөс түүнд оролцогчдын нэр, албан тушаал, мэргэшлийн талаар мэдэгдэж, бичиг баримтаа илгээхийг хүсэх;

7.4.12. Хурлын тэмдэглэлийн төслийг бэлтгэх.

НАЙМ.ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ ТОГТООХ

8.1. Анхны уулзалтын үеэр (биечлэн эсхүл цахимаар хийж болно) эвлэрүүлэн зуучлагч нь талуудын ашиг сонирхолд нийцүүлэн, шударга, зөв, үр дүнтэй болгохыг зорин хурлын үеэр дагаж мөрдөх **Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах журмын төслийг** талууд болон тэдний өмгөөлөгчид гаргаж өгнө.

8.2. Эвлэрүүлэн зуучлагч харилцан тохиролцсон Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмын тухай, холбогдох үүрэг амлалтыг талуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

8.3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журамд дараах асуудлыг тусгана.

8.3.1. Сонгосон платформ, баримт бичиг дамжуулах, гарын үсэг зурах горимын заалт;

8.3.2. Аюулгүй, өндөр хурдтай интернет холболт, хангалттай компьютер, микрофон, видео камер ашиглах тухай;

8.3.3. Имэйл болон мессежийн ирж байгаа мэдэгдлийн дууг (notification) унтраах тухай;

8.3.4. Интернет сүлжээний тасалдлыг хэрхэн зохицуулах тухай (жишээ нь, Асуудал гарсан тохиолдолд зуучлагчтай шууд утсаар эсвэл цахим шуудангаар холбогдож, боломжит шийдлүүдийг үнэлж, шийдвэрлэнэ);

8.3.5. Технологийн саатлын протокол (жишээлбэл, уулзалтыг хойшлуулах эсвэл утсаар (хурлын дуудлага) хийх эсэхийг нэн даруй тохиролцож, бүх оролцогчдын утасны дугаарыг урьдчилан зааж өгнө.);

8.3.6. Мэдээллийн платформтой холбогдох арга, хуралдааныг техникийн аргаар явуулах тухай товч тайлбар;

8.3.7. Уулзалт явуулах арга замын талаарх товч тайлбар (хамтарсан хуралдаан, завсарлагааны танхим гэх мэт);

8.3.8. Хамтарсан болон бүлгийн хуралдааны үеэр харилцах үндсэн дүрэм;

8.3.9. Хувийн нууц ба нууцлалыг хамгаалах үүрэг хариуцлага;

8.3.10. Маргааныг шийдвэрлэхийн тулд сайн санааны үүднээс хэлэлцээ хийх амлалт.

ЕС.ЦАХИМ УУЛЗАЛТ

9.1. Цахим эвлэрүүлэн зуучлалын уулзалтыг дараах журмаар хийнэ.

9.1.1. Зуучлагч товлосон цагаасаа 15 минутын өмнө платформтой холбогдоно.

9.1.2. Холбохын өмнө зуучлагч өөрийн дэвсгэр (background), гэрэлтүүлэг, дэлгэцийн хүрээ зэргийг цэгцэлнэ.

9.1.3. Эвлэрүүлэн зуучлагч талуудыг уулзалтад оруулахын өмнө эвлэрүүлэн зуучлалын бүх оролцогчдыг хүлээлгийн танхимд /waiting room/ байлцуулна.

9.1.4. Бүх оролцогчид нэгдэсний дараа эвлэрүүлэн зуучлагч хамтарсан уулзалтыг /joint session/ нээж, дараах журмаар уулзалтыг явуулна.

9.1.4.1. Эвлэрүүлэн зуучлалын талаар болон уулзалтыг хэрхэн явуулах талаар эвлэрүүлэн зуучлагч товч танилцуулга, тайлбар хийнэ.

9.1.4.2. Эвлэрүүлэн зуучлагч талуудаас эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хүлээн зөвшөөрсөн эсэхээ мэдэгдэж, онлайн эвлэрүүлэн зуучлалын үндсэн дүрмийг агуулсан Эвлэрүүлэн зуучлалын журамд гарын үсэг зурахыг хүснэ.

9.1.4.3. Эвлэрүүлэн зуучлагч талуудаас байр сууриа илэрхийлэхийг хүснэ.

9.1.4.4. Зуучлагч талуудын байр суурийг нэгтгэн дүгнэнэ.

9.1.5. Шаардлагатай тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч талуудыг уулзалтын танхимд хувааж, тус бүрээр нь бүлгийн уулзалтыг эхлүүлнэ. Энэхүү бүлгийн хаалттай уулзалтанд:

9.1.5.1. Эвлэрүүлэн зуучлагч талуудаас байр сууриа чөлөөтэй илэрхийлэхийг хүсч, талуудын бодит ашиг сонирхлын хэрэгцээг судлахыг хичээнэ.

9.1.5.2. Эвлэрүүлэн зуучлагч нь уулзалтыг дүгнэж, тухайн талаас эсрэг талдаа байр сууриа илэрхийлэхийг хүснэ.

9.1.6. Дараагийн хамтарсан уулзалт:

9.1.6.1. Эвлэрүүлэн зуучлагч нь сүлийн уулзалтаар ямар асуудлыг ярилцсаныг танилцуулна.

9.1.6.2. Эвлэрүүлэн зуучлагч талуудыг уулзалтын үеэр маргааныг шийдвэрлэх бүх хувилбарыг судалж, хэлэлцэхийг урина.

9.1.6.3. Эвлэрсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч талуудыг нөхцөлийг тодорхой зааж, эвлэрлийн гэрээний төслийн агуулгыг гаргахыг урина.

9.1.6.4. Төгсгөлд нь хурлын тэмдэглэл, шаардлагатай бол Эвлэрлийн гэрээг дэлгэцэн дээр танилцуулж, оролцогчдын зөвшөөрлийг авна.

9.1.7. Сүүлийн шат:

9.1.7.1. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн анхны уулзалтаар тохиролцсон журам, журмын дагуу тохиролцсон баримт бичгийг талуудад илгээж, гарын үсэг зурна.

АРАВ.ХОЛИМОГ ХЭЛБЭР

10.1. Цахим эвлэрүүлэн зуучлалын нэг давуу тал нь талууд нэг газар байхгүй ч алсаас холбогдож эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжтой явдал юм. Эвлэрүүлэн зуучлалыг биечлэн эхлүүлсэн эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үе шатанд гэнэтийн биечлэн оролцож чадахгүй нөхцөл байдал үүссэн бол талууд цахим эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шилжиж болно. Цахим эвлэрүүлэн зуучлалд шилжихээр шийдсэний дараа талууд цахим эвлэрүүлэн зуучлалын дүрмийг дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч талуудыг цахим эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэхээр тохиролцсон журам, тохиролцоонд гарын үсэг зурахыг урьж, эсвэл тэмдэглэлд талууд гарын үсэг зурсан байх ёстой.

10.2. Үүнтэй адилаар талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цахимаар явуулж эхэлсний дараа талууд тодорхой шалтгаанаар биечлэн уулзаж, эвлэрүүлэн зуучлалыг нүүр тулан эцэслэхийг хүсэж байгаа тохиолдолд дараагийн уулзалтыг биечлэн явуулж болно.

10.3. Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болж, эвлэрэлд хүрэх шатанд биечлэн уулзах нь чухал байж болно. Мөн ажиллагааны төгсөл үед эвлэрүүлэн зуучлагч талуудад биечлэн уулзаж, эвлэрүүлэн зуучлах гэрээ байгуулж, биечлэн гарын үсэг зурахыг санал болгож болно.

АРВАН НЭГ.ЭВЛЭРЭЛ

11.1.Талууд эвлэрлийн гэрээ байгуулсны дараа эвлэрүүлэн зуучлагч нь Эвлэрлийн гэрээг нэн даруй харьяаллын дагуу шүүхэд шилжүүлж, баталгаажуулахаар Эвлэрүүлэн зуучлагчийн төвд хүргүүлнэ.

ХАВСРАЛТ. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ЦАХИМААР АМЖИЛТТАЙ ЯВУУЛАХ ЗӨВЛӨГӨӨ

Биечлэн болон цахим зуучлал нь зарим ялгаа, давуу, сул талтай байдаг бөгөөд сайн зуучлагч эрсдэлийг багасгах боломжтой юм. Талууд болон тэдний өмгөөлөгчид онлайн эвлэрүүлэн зуучлалын онцлогийг харгалзан арга барил, зан үйлээ өөрчлөх ёстой.

1. Зуучлагч

Мэргэжлийн, туршлагатай эвлэрүүлэн зуучлагч нь онлайн эвлэрүүлэн зуучлалыг зөв, үр дүнтэй явуулахын тулд дараахь зүйлийг хийх ёстой.

1. Видео хурлын платформ хэрхэн ажилладаг, тэдгээртэй танилцаж, техникийн болон технологийн боломжит доголдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар сайтар ойлгоход цаг заваа зориулах;
2. Тоног төхөөрөмжөө (микрофон, камертай ширээний эсвэл зөөврийн компьютер, өндөр хурдны интернет холболт), арын дэвсгэр (background), гэрэлтүүлэг, хувцаслалтаа оновчтой болгож, шалгах;
3. Талууд болон тэдний зөвлөхүүд сонгосон платформтой танилцсан эсэх, мөн платформыг хэрхэн холбох, удирдах, төхөөрөмж, орчин, гэрэлтүүлгийг хэрхэн зохион байгуулах талаар заавар, зөвлөмж өгөхөд бэлэн байгаа эсэх, өндөр хурдны интернет холболттой эсэхийг шалгах;
4. Уулзалтын цагийг зохион байгуулж, завсарлагаа төлөвлөх;
5. Маргаантай баримтуудыг илүү сайн ойлгож эхлэхийн тулд уулзалт болохоос өмнө талуудтай холбоо тогтоох боломжийг авч үзэх;
6. Бүх талууд болон зөвлөхүүд товлосон өдрөө видео хуралд оролцох цаг гаргаж, оролцоход бүрэн бэлэн байгаа эсэхийг шалгах;
7. Талуудтай 2 дахь хувилбарыг (утас болон бусад) тохиролцож, утасны дугаараа солилцох;

8. Бүх оролцогчдыг эхнээс нь тодорхойлж, бусад нь хэн болох, тэдний чиг үүргийг (талууд, гол шийдвэр гаргагч, зөвлөх гэх мэт) ойлгосон эсэхийг шалгах;
9. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг аль болох эрт тогтоох;
10. Шаардлагатай эсвэл тохиромжтой үед "чат" (хувь хүн рүү эсвэл бүх бүлэгт мессеж илгээх) ашиглах;
11. Оролцогчдын аман бус мессежийг уншиж, тайлбарлахад онцгой анхаарал хандуулах (үүнийг хийхийн тулд зуучлагч видеоны зохион байгуулалтыг тохируулах ёстой – галерей харах, идэвхтэй яригч харах гэх мэт).

2. Талууд

Онлайн зуучлалын хүрээнд маргааныг шийдвэрлэхийг сонирхож буй тал дараахь зүйлийг хийх ёстой.

1. Хангалттай тоног төхөөрөмж (микрофон, камертай ширээний эсвэл зөөврийн компьютер), өндөр хурдны интернет холболттой байх;
2. Сонгосон платформтой байх эсвэл түүнийг мэддэг байх;
3. Сонгосон технологийн талаар мэдлэг дутмаг байвал эвлэрүүлэн зуучлагчаас зуучлалын хуралдаан эхлэхээс өмнө заавар авахыг хүсэх;
4. Онлайн зуучлалын журмын талаар шаардлагатай бол зуучлагчаас тодруулга авах;
5. Эвлэрүүлэн зуучлалын хуралдаан эхлэхээс өмнө өмгөөлөгчтэйгээ уулзаж, баримтлах стратегийн талаар зөвшилцөх,
6. "Чат"-ыг (хувь хүн рүү эсвэл бүх бүлэгт мессеж илгээх) шаардлагатай эсвэл тохиромжтой үед зөвхөн зохион байгуулалтын асуудалтай холбоотой ашиглах;
7. Бусад хүмүүс ярьж байх үед микрофоны дууг хаах;
8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг дагаж мөрдөх;
9. Шаардлагатай бол завсарлага хүсэх;
10. Нээлттэй байх;

11. Сөргөлдөөнтэй биш, хамтын ажиллагаатай байх.

3. Хуульч, Өмгөөлөгч

Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчдээ онлайн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд зохих ёсоор, мэргэжлийн туслалцаа үзүүлэхийн тулд дараахь зүйлийг хийх ёстой.

1. Хангалттай тоног төхөөрөмж (микрофон, камертай ширээний эсвэл зөөврийн компьютер), өндөр хурдны интернет холболттой байх;
2. Сонгосон платформтой байх эсвэл түүнийг мэддэг байх;
3. Сонгосон технологийн талаар мэдлэг дутмаг байвал эвлэрүүлэн зуучлагчаас зуучлалын хуралдаан эхлэхээс өмнө заавар авахыг хүсэх;
4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлог, онлайнаар хийгдэж буй үйл ажиллагааны онцлогийг үйлчлүүлэгчдээ тодорхой тайлбарлаж, нөгөө талтай хамтран шийдвэр гаргагч байх боломжтой гэдгийг ойлгуулах;
5. Эвлэрүүлэн зуучлах хуралдааны үеэр тэрээр үйлчлүүлэгчээс өөр байршилд байх тул онлайн уулзалтын онцлогийг харгалзан үйлчлүүлэгчийг зохих ёсоор бэлтгэхэд илүү анхаарал хандуулах;
6. Эвлэрүүлэн зуучлалын явцад үйлчлүүлэгчтэй шаардлагатай бол утсаар ярих арга замыг зохион байгуулах;
7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмгөөлөгч нь шүүхэд ханддаг шиг маргалдах арга барилгүй гэдгийг үйлчлүүлэгчдээ ойлгуулах;
8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайтар бэлтгэж, үйлчлүүлэгчтэйгээ хамтран түүний бодит сонирхол, хэрэгцээг ойлгож, түүнд тохирсон стратегийг төлөвлөх;
9. Эвлэрүүлэн зуучлагчаас бүх оролцогчид болон тэдний үүргийг тодорхойлохыг хүсэх;
10. Үйлчлүүлэгчийн эрх ашгийн үүднээс зуучлагчтай хамтран ажиллах;
11. Эвлэрүүлэн зуучлалын хуралдааны явцад эвлэрлийн гэрээний төсөлтэй байх эсвэл төслийг боловсруулахад бэлэн байх.